

2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАСТ

Монголын Үнэт Цаасны Бирж ХК нь “Хөрөнгийн зах зээлийн үр өгөөжийг хүн бүрт ойлгуулахад чиглэсэн түргэн шуурхай, найдвартай биржийн цогц системийг бий болгох” гэсэн өөрийн эрхэм зорилгын хүрээнд, хуулиар хүлээсэн үндсэн үүрэгт ажил болох үнэт цаасны арилжааг болон арилжаанд оролцогчдыг зохион байгуулах, бүртгэх, арилжааны дараах төлбөр тооцоог гүйцэтгэх, эрсдэлийг удирдах, олон нийтийг арилжааны болон бусад шаардлагатай мэдээллээр ил тод, шуурхай хангах үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.

Биржийн болон биржийн бус зах зээл дээр үнэт цаас гаргахаар төлөвлөж буй компаниудын ирүүлсэн төсөл, бичиг баримтыг шалгаж, шаардлагатай зөвлөгөө зааварчилгааг өгч, энэ оны сүүлийн хагаст арилжаанд оруулах бэлтгэлийг базааж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар хоёр компанийн биржийн бус зах зээлийн бондын төлбөр тооцоог гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан.

Бирж өөрийн хувьцааг олон нийтэд нээлттэй санал болгож, хөрөнгө оруулалт босгохоор төлөвлөж байгаа бөгөөд энэ нь Биржийн стратеги төлөвлөгөөнд тусгагдсан Насдак группын арилжаа, төлбөр тооцооны цогц системийг суурилуулах ажлыг эхлүүлэх нөхцлийг бүрдүүлнэ. Биржийн системийг шинэчилснээр үүсмэл санхүүгийн хэрэгсэл зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээлд шуурхай нэвтрүүлэх, түүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой болно.

Бүртгэл

Бирж дээр бүртгүүлэх хүсэлт гаргасан компаниудын үйл ажиллагаа болон ирүүлсэн бичиг баримттай танилцах, өргөдлийг шийдвэрлэх, зөвлөгөө өгөх ажил тогтмол хийгдэж байдаг.

Биржийн бүртгэлийн шаардлагын дагуу Бирж дээр бүртгэгдсэн компани бүр олон нийтэд нийцүүлэгчээрээ дамжуулан үйл ажиллагааны мэдээ мэдээллээ тогтмол гаргадаг бөгөөд энэ нь тус Биржийн давуу талын нэг юм. Холбогдох хууль, дүрэм журмын дагуу Анд-Энерги ХК, Минж Проперти ХХК-ийн олон нийтэд тогтмол мэдээлэх мэдээллийн нээлттэй байдалд тэдгээрийн нийцүүлэгчдээр дамжуулан хяналт явуулах ажиллагаа тогтмол хийгдэж байна.

Биржид бүртгэлтэй компаниудын мэдээллийг Биржийн хөтөлдөг www.msx.mn болон www.market.msx.mn цахим хуудаснуудаас авах боломжтой. Эдгээр цахим хуудаст мөн Бирж дээр үнэт цаас гаргах болон арилжаанд оролцох боломж, давуу тал, төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлага, гишүүнчлэлийн мэдээллүүд, үнэт цаасны арилжааны болон ханшийн мэдээ, үнэт цаас гаргагч компаниудын мэдээ, тайлангуудыг зохих хугацаанд нь гаргаж байдаг.

Арилжаа

Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд нийт 123 өдрийн арилжаа явагдаж, Анд Энерги ХК-ийн 5,127,500 ширхэг хувьцаа 228,940,200 төгрөгөөр арилжаалагдсан. AND хувьцааны дээд ханш 48.48 төгрөг, доод ханш 38.60 төгрөг, жигнэсэн дундаж нь 44.65 төгрөг байлаа. Мөн оны эхний хагаст Минж Проперти ХХК-ийн Парк таун бондын нийт 9000 ширхэг РТВ өрийн бичгийн 90,000,000 төгрөгийн арилжаа явагдсан байна.

Хүснэгт 1. Арилжааны дүн (сараар)

	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар
AND						
Арилжааны дүн (төгрөг)	7,269,700	1,337,500	1,018,100	1,390,400	4,122,700	2,976,800
Арилжигдсан тоо (ширхэг)	175,200	32,500	21,000	32,600	106,800	74,400
Багцын арилжааны дүн (төгрөг)	210,825,000					
Багцын арилжааны тоо (ширхэг)	4,685,000					
РТВ						
Арилжааны дүн (төгрөг)	50,000,000				40,000,000	
Арилжигдсан тоо (ширхэг)	5,000				4,000	


Монголын Үнэт Цаасны Бирж 2018 онд 10 гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байсан бол 2019 оны эхний хагас жилийн байдлаар хоёр гишүүн шинээр нэмэгдэж, нийт 12 гишүүн үнэт цаасны компани, хоёр клирингийн гишүүнтэй хамтран ажиллаж байна.

Төлбөр тооцоо

Биржийн Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын алба нь 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Анд-Энерги ХК-ийн 10,255,000 ширхэг AND хувьцаа, Минж Проперти ХХК-ийн 18,000 ширхэг РТВ өрийн бичгийн нийт 637,880,400 төгрөгийн төлбөр тооцоог гүйцэтгэсэн. Үүнээс Нэрэн клиринг ХХК 533,096,700 төгрөгийн, Харз трейд ББСБ ХХК 104,783,700 төгрөгийн төлбөрийг тус тус гүйцэтгэжээ.

2019 оны эхний хагас жилийн төлбөр тооцоо гүйцэтгэсэн дүн өмнөх оны эхний хагас жилийн дүнгээс 39.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 1. Төлбөр гүйцэтгэсэн хэлцлийн дүн (сая төгрөгөөр, сараар)



Энэ хугацаанд нийт 103 хэлцэл хийгдсэнээс Анд-Энерги ХК-ийн 879,000 ширхэг AND хувьцааны төлбөр 35,978,400 төгрөгийг Т+2 хугацаанд төлөх 99 нээлттэй позиц үүсгэж, позицыг хугацаанд нь бүрэн хаасан байна.

График 2. Ханшийн өөрчлөлт, 2019 оны эхний хагас жил



Дээрх графикаас харахад нэг болон хоёр өдрийн дотор ханш 25%-аас илүү өөрчлөгдсөн тохиолдол гарсан ч энэ нь дэнчингийн доод түвшинг ихэсгэхүйц нөлөө үзүүлээгүй. Тиймээс төлбөрийн одоогийн мөрдөгдөж буй дэнчингийн хувь нь эрсдэлийг хаах боломжит хэмжээнд байна гэж үзэж болно. Тус хувийг бууруулж хөрөнгө оруулагчдын урьдчилан байршуулах мөнгийг багасгах боломжтой хэдий ч, энэ нь төлбөрийн эрсдэлийг нэмэгдүүлэх сул талтай.

Бирж дээр Ковент ТМ ХХК-ийн “Мабу бонд” 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр, Тэлмэн констракшн ХХК-ийн “Нийслэл бонд” 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдөр биржийн бус зах зээл дээр бүртгэгдэж, төлбөр тооцоогоо гүйцэтгүүлж байна.

Санхүү

Монголын Үнэт Цаасны Бирж ХК нь 2019 оны эхний хагас жилд 240.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт татаж, үйл ажиллагааны зардалд зарцуулсан бөгөөд санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Капиталын бүтцээр авч үзвэл нийт эх үүсвэрийн 92.5%-ийг өөрийн хөрөнгө бүрдүүлснээс гадна эргэлтийн харьцаа 17.4% байна.

Тайлант хугацаанд Бирж 3.1 сая төгрөгийн шимтгэлийн орлого олсон бол 534.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 2. Орлогын дэлгэрэнгүй тайлан (сая төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2018 оны дүн	2019 оны эхний хагасын дүн
1	Борлуулалтын орлого	6.63	3.09
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	6.63	3.09
4	Хүүний орлого	12.70	0.99
5	Бусад орлого	19.89	21.34
6	Ерөнхий ба удирдлагын зардал	570.66	306.85
7	Санхүүгийн зардал	47.25	16.32
8	Бусад зардал	0.75	0.15
9	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (гарз)	(0.87)	0.01
10	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(236.25)
11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(580.31)	(534.14)
12	Орлогын татварын зардал	1.27	0.1
13	Татварын дараах ашиг (алдагдал)	(581.58)	(534.24)

Компанийн ТУЗ-ийн болон хувьцаа эзэмшигчдийн хурал

Тайлант хугацаанд ТУЗ-ийн хурал нийт 6 удаа хуралдаж, нийт 14 асуудал хэлэлцэн хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар 17 тогтоол гаргаж баталгаажуулсан. Үүнд, Компанийн бүтэц, зохион байгуулалт, дотоод үйл ажиллагаанд чиглэл өгөх, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх, удирдлагаар хангах, IPO гаргах бэлтгэл ажил, түүнчлэн Биржийн гишүүн элсүүлэхтэй холбоотой тогтоолуудыг гаргасан байна.

ТУЗ-ийн гишүүдийн тоо болон ТУЗ-ийн дэргэдэх хороод 2019 онд өөрчлөгдөөгүй, есөн гишүүнтэй ТУЗ-ийн бүрэлдэхүүн хэвээр байна.

Монголын Үнэт Цаасны Бирж ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хуралдаж, Компанийн 2018 оны үйл ажиллагаанд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг баталж тогтоол гаргасан. Тус хурал дээр Биржийн 2019 оны болон дунд хугацааны төлөвлөгөө хувьцаа эзэмшигчдэд танилцуулагдсан байна.